



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/525

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Япон Улсын "Зүрх хамгаалах төсөл" ашгийн бус байгууллага хооронд 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 4 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

2017 оны 12 сарын 20-ны өдрийн
 15.85 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИЛГЭЛ,
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Катоака Коичи Kataoka Koichi	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭЭ0001855	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх төрөл	2017.12.20 2017.12.27 /7 хоног/
2.	Томиита Хидэши Tomita Hideshi	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭЭ0001856	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	2017.12.20 2017.12.27 /7 хоног/
3.	Кимура Масато Kimura Masato	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭЭ0001857	Хүүхдийн зүрх судлал	Эмчлэх	2017.12.20 2017.12.27 /7 хоног/
4.	Фүжи Соноко Fujii Sonoko	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭЭ0001858	Мэдээгүйжүүлэг судлал	Эмчлэх	2017.12.20 2017.12.27 /7 хоног/